

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
2023 он	Аудитор: З.Золбоо Утас: 7036-2442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.24 № СЭА-2023/88/НА-СТА-ТШБ
танай _____-ны № _____-г

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЫН ДУУ
БҮЖГИЙН СЭЛЭНГИЙН ДОЛГИО
ЧУУЛГЫН ДАРГА Д.УРАНБИЛЭГ
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 90.1 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 7.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6.8 хувиар, тогтмол зардлыг 17.9 хувиар, хангамж бараа материалын зардлыг 8.6 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт батлагдсан төсөв 9.9 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 59.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн, 24.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	231,064,299.00	303,641,462.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	54,162,010.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	54,162,010.54
3121	Төгрөг	-	54,162,010.54
31211	Төрийн сангийн харилцах	-	54,162,010.54
35	БАРАА МАТЕРИАЛ	231,064,299.00	249,479,452.00
354	Хангамжийн материал	231,064,299.00	249,479,452.00
3541	Бичиг хэргийн материал	153,300.00	561,400.00
3542	Аж ахуйн материал	4,178,080.00	4,568,080.00
3544	Түлш, шатах тослох материал	130,000.00	-
3547	Бусад хангамжийн материал	226,602,919.00	244,349,972.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,183,439,566.79	1,121,842,403.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,183,439,566.79	1,121,842,403.39
392	Биет хөрөнгө	1,132,897,566.79	1,070,202,903.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,055,715,659.47	1,055,715,659.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,503,607.88)	(142,491,760.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,840,000.00	81,840,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,889,266.84)	(81,840,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,224,850.00	217,779,532.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,812.50)	(93,739,776.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,044,195.50	92,640,521.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,430,645.70)	(65,146,636.19)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,442,401.42	6,442,401.42
39210	Хуримтлагдсан элэгдэл	(690,257.16)	(997,038.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	227,110,131.00	3,162,723.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(83,958,080.52)	(3,162,722.92)
393	Биет бус хөрөнгө	50,542,000.00	51,639,499.96
39303	Бусад биет бус хөрөнгө	50,542,000.00	52,342,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(702,500.04)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,414,503,865.79	1,425,483,865.93
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	259,690.58	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	259,690.58	-
413	Өглөг	259,690.58	-
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	259,690.58	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,414,244,175.21	1,425,483,865.93
51	Засгийн газрын хувь оролцоо	1,414,244,175.21	1,425,483,865.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	726,026,057.50	726,026,057.50
51101	Өмч: - төрийн	726,026,057.50	726,026,057.50
512	Хуримтлагдсан үр дүн	(427,344,558.40)	(416,104,867.68)
5121	Өмнөх үеийн үр дүн	(427,344,558.40)	(1,841,849,110.19)
5122	Тайлант үеийн үр дүн	-	1,425,744,242.51
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,115,562,676.11	1,115,562,676.11

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,414,503,865.79	1,425,483,865.93
----	--	------------------	------------------



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,291,176,059.0	2,518,690,221.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	436,383,173.0	1,471,886,703.8
120	Нийтлэг татварын бус орлого	14,484,573.0	1,471,886,703.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,484,573.0	45,011,450.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,568,650.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,442,800.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,484,573.0	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	1,183,770,252.8
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	243,105,001.0
122	Тусламжийн орлого	421,898,600.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,792,886.0	1,046,803,517.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,094,160.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,980,000.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,114,160.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	838,698,726.0	289,422,217.4
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	838,698,726.0	289,422,217.4
1330	Төсвийн захирагчдаас	-	757,381,300.0
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	757,381,300.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	927,625,918.0	1,092,945,978.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	927,625,918.0	1,092,945,978.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,852,918.0	1,044,318,546.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,219,554.0	550,993,125.2
210101	Үндсэн цалин	447,854,884.6	446,053,171.3
210102	Нэмэгдэл	122,364,669.5	80,429,200.9
210104	Урамшуулал	-	24,510,753.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,889,544.0	69,628,278.7
210201	Тэтгэврийн даатгал	52,649,857.3	48,346,533.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,860,570.1	5,690,779.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,644,776.1	4,438,383.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,758.3	1,013,871.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,667,582.3	10,138,711.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,723,052.5	251,773,660.4
210301	Гэрэл, цахилгаан	4,408,030.8	6,596,917.4
210302	Түлш, халаалт	159,332,689.7	238,950,393.0
210303	Цэвэр, бохир ус	4,982,332.0	6,226,350.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,948,526.0	18,366,499.0

210401	Бичиг хэрэг	664,000.0	1,304,900.0
210402	Тээвэр, шатахуун	450,800.0	1,795,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,489,986.0	1,481,220.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,100.0	170,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,148,640.0	2,799,130.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	19,000.0
210408	Бараа материал акталсны зардал	-	10,797,249.0
2105	Нормативт зардал	56,500.0	300,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,500.0	300,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,755,000.0	13,293,985.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	165,000.0
210604	Урсгал засвар	1,755,000.0	13,128,985.0
2107	Томилолт, зочны зардал	-	11,336,200.0
210702	Дотоод албан томилолт	-	11,336,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,973,100.0	38,026,035.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,705,800.0	38,026,035.0
210803	Даатгалын үйлчилгээ	155,000.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,300.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,287,641.5	90,600,763.4
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,287,641.5	90,600,763.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,773,000.0	48,627,432.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,773,000.0	48,627,432.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	41,557,432.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,773,000.0	7,070,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	363,550,141.0	1,425,744,242.5
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	363,550,141.0	1,425,744,242.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	857,992,886.0	1,091,814,967.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,200,000.0	45,011,450.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	45,011,450.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	45,011,450.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,568,650.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,442,800.0
122	Тусламжийн орлого	3,200,000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,792,886.0	1,046,803,517.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,094,160.0	-

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,980,000.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,114,160.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	838,698,726.0	289,422,217.4
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	838,698,726.0	289,422,217.4
1330	Төсвийн захирагчдаас	-	757,381,300.0
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	757,381,300.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	852,217,886.0	1,008,979,356.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	852,217,886.0	1,008,979,356.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,444,886.0	960,351,924.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,959,863.5	550,652,815.8
210101	Үндсэн цалин	447,595,194.0	445,712,861.8
210102	Нэмэгдэл	122,364,669.5	80,429,200.9
210104	Урамшуулал	-	24,510,753.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,889,544.0	69,628,278.7
210201	Тэтгэврийн даатгал	52,649,857.3	48,346,533.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,860,570.1	5,690,779.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,644,776.1	4,438,383.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,758.3	1,013,871.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,667,582.3	10,138,711.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,723,052.5	251,773,660.4
210301	Гэрэл, цахилгаан	4,408,030.8	6,596,917.4
210302	Түлш, халаалт	159,332,689.7	238,950,393.0
210303	Цэвэр, бохир ус	4,982,332.0	6,226,350.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,171,076.0	9,493,825.0
210401	Бичиг хэрэг	817,300.0	1,443,400.0
210402	Тээвэр, шатахуун	580,800.0	2,265,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,489,986.0	1,481,220.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,100.0	170,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,087,890.0	4,134,205.0
2105	Нормативт зардал	102,750.0	4,800,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,750.0	4,800,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,755,000.0	12,744,710.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	210,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	555,000.0
210604	Урсгал засвар	1,755,000.0	11,979,710.0
2107	Томилолт, зочны зардал	-	11,336,200.0
210702	Дотоод албан томилолт	-	11,336,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,843,600.0	49,922,435.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,576,300.0	49,922,435.0
210803	Даатгалын үйлчилгээ	155,000.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,300.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.0	-

436
 436
 436
 436
 436

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,773,000.0	48,627,432.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,773,000.0	48,627,432.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	41,557,432.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,773,000.0	7,070,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,775,000.0	82,835,610.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,575,000.0	28,673,600.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	2,575,000.0	28,673,600.0
	Дотоод эх үүсвэрээр	2,575,000.0	28,673,600.0
222001	Тоног төхөөрөмж	375,000.0	23,926,700.0
223001	Бусад хөрөнгө	2,200,000.0	4,746,900.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,575,000.0)	(28,673,600.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,200,000.0	54,162,010.5
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	54,162,010.5

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/


Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.5	1,115,562,676.1	(368,996,099.4)	1,472,592,634.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Тайлант үеийн үр дүн			(58,348,459.1)	(58,348,459.1)
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.5	1,115,562,676.1	(427,344,558.4)	1,414,244,175.2
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,414,504,551.8)	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
11	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
12	Тайлант үеийн үр дүн			1,425,744,242.5	1,425,744,242.5
13	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.5	1,115,562,676.1	(416,104,867.7)	1,425,483,865.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,151,269,600.0	1,037,652,956.8	113,616,643.2	90.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,151,269,600.0	1,037,652,956.8	113,616,643.2	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,100,722,600.0	989,025,524.8	111,697,075.2	89.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,402,300.0	550,652,815.8	46,749,484.3	92.2
210101	Үндсэн цалин	453,427,300.0	445,712,861.8	7,714,438.2	98.3
210102	Нэмэгдэл	115,640,300.0	80,429,200.9	35,211,099.1	69.6
210104	Урамшуулал	28,334,700.0	24,510,753.0	3,823,947.0	86.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,723,700.0	69,628,278.7	5,095,421.3	93.2
210201	Тэтгэврийн даатгал	50,000,600.0	48,346,533.0	1,654,067.0	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,180,800.0	5,690,779.7	490,020.3	92.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,944,700.0	4,438,383.7	506,316.3	89.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,236,100.0	1,013,871.1	222,228.9	82.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,361,500.0	10,138,711.2	2,222,788.8	82.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	306,515,100.0	251,773,660.4	54,741,439.6	82.1
210301	Гэрэл, цахилгаан	60,000,000.0	6,596,917.4	53,403,082.6	11.0
210302	Түлш, халаалт	238,856,000.0	238,950,393.0	(94,393.0)	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,659,100.0	6,226,350.0	1,432,750.0	81.3
2104	Хангамж, бараа материалын зардал	10,391,700.0	9,493,825.0	897,875.0	91.4
210401	Бичиг хэрэг	1,788,200.0	1,443,400.0	344,800.0	80.7
210402	Тээвэр, шатахуун	2,277,000.0	2,265,000.0	12,000.0	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,692,000.0	1,481,220.0	210,780.0	87.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.0	170,000.0	330,000.0	34.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,134,500.0	4,134,205.0	295.0	100.0
2105	Нормативт зардал	4,842,000.0	4,800,000.0	42,000.0	99.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,842,000.0	4,800,000.0	42,000.0	99.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,951,000.0	35,398,510.0	2,552,490.0	93.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,887,500.0	19,916,900.0	1,970,600.0	91.0
210602	Тавилга	3,000,000.0	2,946,900.0	53,100.0	98.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	703,700.0	555,000.0	148,700.0	78.9
210604	Урсгал засвар	12,359,800.0	11,979,710.0	380,090.0	96.9
2107	Томилолт, зочны зардал	11,336,500.0	11,336,200.0	300.0	100.0
210702	Дотоод албан томилолт	11,336,500.0	11,336,200.0	300.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,560,300.0	55,942,235.0	1,618,065.0	97.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,560,300.0	55,942,235.0	1,618,065.0	97.2

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,547,000.0	48,627,432.0	1,919,568.0	96.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,547,000.0	48,627,432.0	1,919,568.0	96.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,279,000.0	41,557,432.0	721,568.0	98.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,268,000.0	7,070,000.0	1,198,000.0	85.5
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,151,269,600.0	1,091,814,967.4	59,454,632.6	94.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,602,600.0	45,011,450.0	2,591,150.0	94.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,602,600.0	45,011,450.0	2,591,150.0	94.6
131103	ЗГНХ,ЗДН хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,442,800.0	25,442,800.0	-	100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,159,800.0	19,568,650.0	2,591,150.0	88.3
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	346,285,700.0	289,422,217.4	56,863,482.6	83.6
132001	Орон нутгийн төсвөөс	346,285,700.0	289,422,217.4	56,863,482.6	83.6
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС	757,381,300.0	757,381,300.0	-	100.0
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	757,381,300.0	757,381,300.0	-	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	54,162,010.5	(54,162,010.5)	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга /цаашид Сэлэнгийн долгио чуулга гэх/ нь 2022 оныг “Ардын болон язгуур урлагийн мөн чанарыг хадгалан хөгжүүлж, орон нутгийн онцлогт тулгуурлан ардын дуу бүжгээр урлагийн бүтээл үйлдвэрлэж, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжинэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Сэлэнгийн долгио чуулгын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлж, үзэгчдийн сэтгэлд үнэлэгдэх өндөр чанартай, хүртээмжтэй уран бүтээл хийх,
- Ардын уламжлалт өв соёлыг орчин үетэйгээ хослуулан хөгжүүлэх,
- Хүн ардад соёлын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд зохион байгуулах,
- Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хүний нөөцийг бүрдүүлэх,
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин


Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатны хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”-с хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,980.0 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	54,162.0	54,162.0
Авлага	-	-	-

Бараа материал	231,064.3	249,479.5	18,415.2
Үндсэн хөрөнгө	1,183,439.6	1,121,842.4	(61,597.2)
Нийт хөрөнгө	1,414,503.9	1,425,483.9	10,980.0
Өр төлбөр	259.7	-	(259.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,414,244.2	1,425,483.9	11,239.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,414,503.9	1,425,483.9	10,980.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 54,162.0 мянган үлдэгдэлтэй тайлагнагдсан нь гүйцэтгэлээр санхүүждэг болсноос шалтгаалан төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 249,479.5 мянган төгрөг болж 18,415.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 51,382.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн ЗДТГ-аас 6,898.1 мянган төгрөгийн тоглолтын хувцас үнэ төлбөргүй авсан болон байгууллагын даргын 2022 оны А/33 дугаар тушаалаар 10,797.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 29,067.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,509,922.8 мянган төгрөг болж 29,003.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,003.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэж, 235,078.1 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж, 235,078.1 мянган төгрөгийн хөрөнгийг анхны өртгөөр данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Өр төлбөрийн данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь байгууллагад төлөх өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,425,483.9 мянган төгрөг болж 11,239.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 1,045,182.8 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зардлыг 114,268.0 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 693,999.7 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 236,915.1 мянган төгрөг, нийт 930,914.8 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны төсвийн төслийн саналын урсгал үйл ажиллагааны зардлыг 114,268.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь 99,367.6 мянган төгрөгийг цалин хөлс, НДШ-ийн зардлаас, 4,295.4 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардлаас, 10,605.0 мянган төгрөгийг эд хогшил урсгал засварын зардлаас тус тус бууруулснаас голлон шалтгаалсан байна.



3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 220,354.8 мянган төгрөгөөр өсгөж 1,151,269.6 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 22,159.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 25,442.8 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, 346,285.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 757,381.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 19,568.7 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 25,442.8 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, 289,422.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 757,381.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэн, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,037,653.0 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 113,616.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	674,334.3	621,315.1	53,019.2	92.1
2	Уран бүтээл хийлгэх	40,000.0	39,996.7	3.3	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	43,047.0	41,907.4	1,139.6	97.4
5	Дээд шатны төсвөөс хуваарилсан	47,602.6	45,011.5	2,591.2	94.6
6	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	316,515.1	261,393.9	55,121.2	82.6
7	Нийтлэг үйлчилгээ	29,770.6	28,028.3	1,742.3	94.1
	Нийт дүн	1,151,269.6	1,037,653.0	113,616.6	90.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Сэлэнгийн долгио чуулгын нэмэлт санхүүжилтийн 10013035404 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,826.3 мянган төгрөг төвлөрснийг тус байгууллагын урсгал зардлын 10013035420 дансанд шилжүүлэн, зарцуулсан байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалыг зарцуулсан тухай бүрд зарлагадаж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгийн долгио чуулгын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 927,625.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,143.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Соёлын газраас “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл”-ийг харьяа байгууллагуудад өгч ажилласны дагуу тус чуулга бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажилласан байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгийн долгио чуулга нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 166 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол төсөв, өмч, хөрөнгө, захиран зарцуулах 1,616.3 мянган төгрөгийн 1 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрүүтэй тооцож олгосон 287.8 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, шатахууны

зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй 5,221.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгснийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.



Хүснэгт 4. Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	287.8	1	287.8	100
Зөвлөмж	2	5,221.5	2	5,221.5	100
Нийт дүн	3	5,509.3	3	5,509.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг хэрэгжүүлсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

1. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна.

Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

2. Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч соёлын салбарын байгууллагуудын онцлогт тохирохгүй тул Соёлын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн НБББББ-ийг мөрдөх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 6,888.1 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрсэнд 800.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,595.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4,492.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг 8 албан хаагчид 800.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.3 дахь “*Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно*”, Хөдөлмөрийн дотоод журмын 8.4.8 дахь “*Галладаг болон түрээсийн байранд амьдардаг өрхөд түлээ, нүүрс авахад тусламж олгож болно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага


1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгээгүй атал 2016-2021 онуудын АТӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр 497.6 мянган төгрөгийг 2022 оны батлагдсан төсвөөс барагдуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3 дахь “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр бүртгэл тайланд бүрэн тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. “Тоглолт, үзвэр үйлчилгээ зохион байгуулах” гэрээнд хөнгөлөлт эдлүүлэхээр тусгагдаагүй байхад заал түрээслэгчдээс 1,098.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг дутуу авч төвлөрүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*”, Тоглолт, үзвэр үйлчилгээ зохион байгуулах 2022 оны 8,10,18 дугаар гэрээний 3.1 дэх “*250 доош үзэгчид үйлчлүүлэхэд 30 хувь, 250-400 үзэгчид үйлчлүүлэхэд 25 хувь, 400 дээш үзэгчид үйлчлүүлэхэд 20 хувь*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт: “Тоглолт , үзвэр үйлчилгээ зохион байгуулах” гэрээний дагуу түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.



5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Батлагдсан төсвийн хуваарьт хугацаа болоогүй байхад буюу 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр “Старкредит ББСБ” ХХК-тай 2022/148 дугаар зээлийн гэрээ байгуулж, 3,419.6 мянган төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийг зээлээр худалдан авч, 5 дугаар сард төлбөрийг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”: 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, зээлээр бараа бүтээгдэхүүн худалдан авахгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,072.9 мянган төгрөгийн аж ахуйн материалыг ажил гүйлгээ гарсан тухай бүр бус бөөн дүнгээр зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн материалын зарлагын гүйлгээг ажил гүйлгээ гарсан тухай бүр хөтлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Үндэслэлгүй хөнгөлөлт олгосон	1	800.0	1	800.0								
Тайлагнагдаагүй өр төлбөр төлсөн	1	497.6			1	497.6						
Гэрээний дагуу орлого төвлөрүүлээгүй	1	1,098.0			1	1,098.0						
Бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан	1	1,072.9					1	1,072.9				
Зээлээр тоног төхөөрөмж худалдан авсан	1	3,419.6					1	3,419.6				
Дүн	5	6,888.1	1	800.0	2	1,595.6	2	4,492.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулах 1 шийдвэрийг мэдээлээгүй	1	1,616.3							1	1,616.3		
Дүн	1	1,616.3							1	1,616.3		